“БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК” ОНӨТҮГ
ТОГТООЛ, ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН 2020 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН МЭДЭЭ

2020 оны 12 дугаар сарын 18 Багануур дүүрэг

| Шийдвэрийн дэс дугаар | Зүйл, заалтын дэс дугаар | Шийдвэрийн нэр, огноо /дугаар, агуулга/ | Хэрэгжилтийн явц | Хэрэгжилтийн хувь | Үнэлгээний хувь | Үнэлгээ, /хүчингүй болсон, хяналтаас хасуулах тухай | Тасарсан болон удааширч байгаа шалтгаан |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| | | | Салбар чиглэл: 1 | | | | |
| 1.е. Засгийн газрын тогтоол | | | | | | | |
| 1. | 1.10. | 2018.02.06<br>№43<br>Агаарын бохирдлыг бууруулах талаар авах зарим арга хэмжээний тухай<br><br>Улаанбаатар хотын дагуул хот, үйлдвэрлэл, технологийн паркийн бүтээн байгуулалтыг эрчимжүүлэхэд шаардагдах хөрөнгийг улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр болон жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгах, гадаадын зээл, тусламжид хамруулах талаар дэмжлэг үзүүлж ажиллахыг Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, Үндэсний хөгжлийн газрын дарга Б.Баярсайхан нарт, дагуул хот, дэд төв, үйлдвэрлэл, технологийн паркийн бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэхийг Барилга, хот байгуулалтын сайд | **Зураг төсөл**<br>➢ **2017 онд** БХБЯ-наас БҮТП-ийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөлт болон инженерийн дэд бүтцийн иж бүрэн зураг төсөл боловсруулах 2 багц ажлын санхүүжилтийн асуудлыг 100% шийдвэрлэсэн.<br>➢ **2018 онд** БХБЯ-наас дээрх 2 зураг төслийг нэгтгэж 1 багц болгон тендэр зарлаж, “Мон-энержи Консалт” ХХК шалгарч №2018/10 тоот гэрээ байгуулсан.<br>➢ **2018-2020 онд** Зураг төслийн ажлыг иж бүрэн гүйцэтгэж 2020.07.07-ны өдөр Паркийн гадна инженерийн шугам сүлжээний зураг төслийн цахилгаанаас бусад хэсэг нь Барилга байгууламжийн зураг төслийн магадлалын 1193/2020 дугаартай нэгдсэн дүгнэлтээр баталгаажсан.<br>➢ Дээрх зураг төслөөр Багануур үйлдвэрлэл, технологийн паркад байгуулагдах үйлдвэрүүдэд тавигдах үндсэн шаардлага, хүний эрүүл мэнд, байгаль орчинд халгүй дэвшилтэт техник, технологийн үйлдвэрүүдийг байгуулахаар зорьж байна.<br>➢ Паркийн нийт /414,0 га/ эзэмшил газарт Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг 2020 | 100% | 100% | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | Х.Баделхан, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Б.Батзориг, Нийслэлийн Засаг дарга С.Батболд нарт; | онд Санни трейд ХХК-аар гүйцэтгүүлж хүлээн авсан.<br>➢ Мөн дээрх газруудад техник, технологийн түвшний үнэлгээг мэргэжлийн байгууллагаар иж бүрэн гүйцэтгүүлсэн.<br>**Хөрөнгө оруулалт, санхүүжилт**<br>➢ БҮТП-ийн дэд бүтэц, нийтийн барилга байгууламж болон ногоон байгууламжуудыг байгуулах хөрөнгө оруулалтын төслийг 2020-2025 он хүртэлх хугацаагаар нарийвчлан тооцон гаргаж, 2021 онд хэрэгжүүлэх төслүүдийн саналуудыг салбарын яамдад 2020.01.24-ний өдрийн 15, 02.07-ны өдрийн 24, 04.22-ны өдрийн 73, 04.27-ны өдрийн 75, 06.03-ны өдрийн 100, 102 дугаартай албан бичгүүдээр тус тус уламжилсан.<br>➢ Нийслэлийн 2020-2025 онд хэрэгжих төсөл арга хэмжээнээс нэн чухал шаардлагатай 6 төслийг 2021 оны Улсын хөрөнгө оруулалтын удирдлагын цахим системд Сангийн сайдын 2018 оны 95 дугаар тушаалаар баталсан журмын дагуу үнэлэн, эрэмбэлэн оруулж ажилласан.<br>➢ МУ-ыг 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хавсралт болох УХОХ-т тусгах төслийн саналыг боловсруулан НШУҮИГ, ҮХГ-т тус тус цахимаар илгээж "Хөрөнгө оруулалтын төслийн нэгдсэн мэдээллийн сан"-г шинэчлүүлэв.<br>➢ Паркийн дэд бүтцийн бүтээн байгуулалтад шаардлагатай хөрөнгө оруулалтын санхүүжилтийн асуудлыг Уул уурхай, Хүнд үйлдвэрлэлийн сайд Г. Ёндон-д 2020.09.23-ны өдрийн 171 дугаартай албан бичгээр уламжилсан.<br>➢ Монгол УИХ-ын гишүүн, ЗГ-ын гишүүн, Монгол улсын сайд, ЗГХЭГ-ын дарга Л. Оюун-Эрдэнэ Багануур дүүрэгт 09 дүгээр сарын 25-ны өдөр ирж удирдлагуудтай уулзалт зохион байгуулсан. Уулзалтаар паркийн удирдлага паркийн өнөөгийн байдал, хөрөнгө оруулалт, статус, паркуудын асуудлыг төрийн бодлогоор яаж эрхлэх талаар санал дэвшүүлсэн.<br>**Дүгнэлт** | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | ✓ БҮТП-ийн үндсэн чиглэлийн хөрөнгө оруулалтын төслүүдийг хүлээн авах, дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлэх үйл ажиллагааг эрчимжүүлэх зорилгоор БХБЯ, ЭХЯ, УУХҮЯ, ХХААХҮЯ-дад хамтран ажиллах тодорхой саналуудыг хүргүүлэн ажиллаж байна.<br>✓ БҮТП-ийн үйл ажиллагааг ЗГ-ын болон Нийслэлийн 2020-2024 оны үйл ажиллагааны аж үйлдвэржилтийн бодлогын зорилго зорилтууд, Алсын хараа-2050, УИХ-ын "Шинэ бүтээн байгуулалт" дунд хугацааны хөтөлбөр, Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэл зэрэгт нийцүүлэх, дээд шатны байгууллагуудтай нягт хамтран уялдаа холбоотой ажиллах нь чухал шаардлагатай учир салбарын яамдтай 8, 10 дугаар сард /ХХААХҮЯ, БОАЖЯ, БШУЯ/ уулзалт зөвлөгөөн зохион байгуулан санал солилцож тодорхой чиглэлийг аван ажиллаж байна. | | | | |
| 2. | 1.2. | 2018.08.22<br>№258<br>Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай<br><br>Иргэдийг ялгаварлан гадуурхахгүй ижил тэгш, зөв шударга харьцаж, төрийн байгууллагад иргэд, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэд тавих хяналтыг сайжруулж, хугацаа хэтэрсэн өргөдөл, гомдлыг 2018 оны 9 дүгээр сарын 1-ний өдөрт багтаан шийдвэрлэж, хариуг өгөх, цаашид өргөдөл, гомдлыг хугацаанд нь бодитой шийдвэрлэж хэвшүүлэх; | ➢ Тайлант онд иргэдээс байгууллагад гаргасан нийт 9 өргөдлийг хүлээн авсан ба хугацаа хэтэрсэн өргөдөл, гомдол байхгүй.<br>➢ НЗД-ын 2018 оны А/1212 дугаар захирамжийн дагуу байгууллагын удирдлага тайлант онд нийт 17 иргэдтэй уулзалт хийж дараах чиглэлээр зөвлөгөө өгч ажилласан.Үүнд:<br>1. Паркийн зорилго чиглэл, үйл ажиллагаа<br>2. Паркийн өнөөгийн байдал<br>3. Паркийн эрх зүйн байдлын хэм хэмжээ<br>4. Паркийн хөрөнгө оруулалтын талаар<br>5. Паркад хэрэгжих боломжтой төсөл, хөтөлбөр | 100% | 100% | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 1.4. | Төрийн жинхэнэ албан тушаалд сул орон тоо гарсан тохиолдолд тухайн байгууллага болон төрийн холбогдох байгууллагад ажиллаж байгаа төрийн жинхэнэ албан хаагчдаас үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшингээр шалгаруулж нөхөн томилох | ➢ Сул орон тоо гарахад үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшингээр шалгаруулж нөхөн томилж ажиллуулсан.<br>➢ Тайлант онд 2 ажилтан ажлаас чөлөөлөгдөж, сул орон тооны зарыг байгууллагын цахим хуудсанд байршуулсан ба шинээр 2 ажилтанг ажилд томилсон. | 100% | 100% | | |
| | 1.7. | Төрийн албан хаагч албан томилолтын явцад, ажлын болон ажлын бус цагаар ажлын байранд согтууруулах ундаа хэрэглэх явдлыг таслан зогсоох, төрийн байгууллагын байр, ажлын байранд согтууруулах ундаа, мансууруулах бодис, галт болон хүйтэн зэвсэг, тэсэрч дэлбэрэх болон шатамхай бодис, хэрэгслийг нэвтрүүлэх, хадгалах, хэрэглэх, ашиглахыг байгууллагын дотоод журамд тусган хориглож, зөрчсөн тохиолдолд хариуцлага тооцох; | Байгууллагын дотоод журамд тусгасан бөгөөд тайлант онд зөрчил гараагүй. | 100% | 100% | | |
| | 1.8. | Төрийн албан хаагчдын үйлдсэн гэмт хэрэг, гаргасан зөрчил, сахилга, ёс зүйн зөрчилд судалгаа, дүн шинжилгээ хийж, шалтгаан нөхцөлийг тогтоон, урьдчилан сэргийлэх арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулах; | Тайлант онд зөрчил гаргасан тохиолдол байхгүй. | 100% | 100% | | |
| | 1.9. | Төрийн байгууллагад ажлын цаг ашиглалтыг хурууны хээний болон камерын | ➢ Байгууллагын цаг бүртгэлийг 2019 оны 2 дугаар сараас эхлэн хурууны хээний машинаар бүртгэж, түүнд хяналт тавин ажиллаж байна. | 100% | 100% | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | хяналтын системээр байнга бүртгэж, түүнд тавих хяналтыг сайжруулах; | ➢ Монгол улсад корона вирусын халдвар бүртгэгдсэнтэй холбогдуулан цахим цаг бүртгэлийн ажлыг эхлүүлэн хяналт тавин ажиллаж байна. | | | | |
| | 9.1 | Нийслэлийн дотоод удирдлагын "UB ERP" системийн цаг бүртгэлийн дэд системд холбогдох тухай | "Монголын цахилгаан холбоо" ТӨХК-аас IP эрх авч байгууллагын цаг бүртгэлийн төхөөрөмжийг "UB ERP" системийн цаг бүртгэлийн дэд системд 2019 онд холбосон.<br>Нийслэлийн "UB ERP" системийг байгууллагын дотоод удирдлагын үйл ажиллагаандаа бүрэн ашиглаж, албан хаагчдын хэрэглээг жигдрүүлсэн.<br>Тайлант онд:<br>✓ ТАХ-ын өөрчлөлтөөр 1 ажилтан албан тушаал дэвшиж, 1 ажилтан албан тушаал буурч, 1 ажилтан нэгж хоорондын шилжилт хөдөлгөөнөөр тушаал дэвшиж, 2 албан хаагч албан тушаал хавсран гүйцэтгэж байна.<br>✓ Сургалт хөгжил дэд системд 1 албан хаагчийн 5 хоногийн сургалтын бүртгэлийг оруулсан.<br>✓ Цаг бүртгэлийн дэд системд албан хаагчдын ажлын цаг ашиглалт, бүртгэлд хяналт тавин ажиллаж байна.<br>✓ НОК-ын 15 дугаар хурлын тэмдэглэлийн дагуу корона вирусын халдвараас урьдчилан сэргийлэх зорилгоор ажилчдын цагийн цаасан бүртгэлийг ERP системийн цаг бүртгэлийн дэд системд нөхөн оруулсан. | 100% | 100% | | |
| 3. | 11 | 2020.01.26<br>№30<br>Шинэ коронавирусийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай<br><br>Шинэ коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх талаар өөрийн байгууллагадаа ухуулга, сурталчилгаа хийх, | ➢ Томуу, томуу төст өвчлөлт болон шинэ корона вирусын халдвараас урьдчилан сэргийлэх, ажилчдын дархлааг сайжруулах зорилгоор дотооддоо 02 дугаар сард "Халуун аарц" аян өрнүүлж ажилласан.<br>➢ Албан хаагчдын амны хаалтын хэрэглээг хэвшүүлэн, ажилчдыг N95 амны хаалт, нэг удаагийн бээлий, Паркийн нэгж болох Монхимо ХХК-ийн амны хаалт, гар халдваргүйжүүлэх нөхцөлөөр ханган, байгууллагын цэвэрлэгээ үйлчилгээний материал, ариутгалын бодис зэргийг хангалттай нөөцлөн, өглөө бүр ажлын байранд чийгтэй | 100% | 100% | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | ажилтнуудын дархлааг дэмжих, амны хаалт хэрэглэх, гар угаах болон халдваргүйжүүлэх нөхцөлийг бүрдүүлж ажиллахыг бүх шатны төрийн байгууллагын дарга, захирал нарт даалгаж, хувийн хэвшлийн байгууллагын ажил олгогч нарт уриалсугай. | цэвэрлэгээг хийж, хаалганы бариулыг 2 цаг тутамд спиртээр ариутгаж байна.<br>➢ ЭМЯ болон дүүргийн ЭМТ-өөс өгч байгаа зөвлөмж, корона вирусын халдвараас урьдчилан сэргийлэх талаарх мэдээлэл, цаг үеийн мэдээг өглөө бүр албан хаагчдад танилцуулан, мэдээллийг www.baganuur-itp.mn цахим хуудсанд тогтмол байршуулж байна. | | | | |
| 4. | 2 | 2020.02.12<br>№62<br>Бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай<br><br>Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдлаар шилжүүлсэнтэй холбогдуулан 17 дугаар жарны Хотол төгс хэмээх төмөр хулгана жилийн Цагаан сарын баярыг тэмдэглэхгүй байх нь зүйтэй гэж үзсүгэй. | Албан хаагчид 17 дугаар жарны Хотол төгс хэмээх төмөр хулгана жилийн Цагаан сарын баярыг зөвхөн өөрсдийн гэр бүлийн хүрээнд тэмдэглэсэн. | 100% | 100% | | |
| | 3 | Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10.4-т заасан арга хэмжээг “Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн хугацаанд авч хэрэгжүүлэх арга хэмжээний удирдамж”-ийн дагуу хэрэгжүүлэн ажиллахыг гамшгаас хамгаалах алба, бүх шатны Засаг дарга, аж ахуйн нэгж, байгууллагын удирдлагад үүрэг болгосугай. | Байгууллагын гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд шинэ корона вирустэй холбоотойгоор нэмэлт заалт оруулан тодотгол хийж албан хаагчдад танилцуулсан. | 100% | 100% | | |
| 5. | 1 | 2020.03.25<br>№106<br>Улсын үзлэгийн мөрөөр авах зарим арга хэмжээний тухай | Нийслэлийн салбар комиссын II ажлын хэсгээс манай байгууллагад 2019 онд “Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн | 100% | 100% | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | "Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэг" үр дүнтэй болсныг тэмдэглэж, үзлэгийн явцад илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээ авч, архив, албан хэрэг хөтлөлттэй холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтэд анхаарч ажиллахыг яам, Засгийн газрын агентлаг, байгууллагын удирдлага, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай. | улсын үзлэг" зохион байгуулахад 95,8%-ийн үзүүлэлттэй амжилттай дүгнэгдсэн.<br>Улсын үзлэгийн мөрөөр ирүүлсэн нийтлэг зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг заалт тус бүрээр гаргаж, хэрэгжилтийг бүрэн хангасан тухай<br>➢ 1 дүгээр улирлын биелэлтийг 2020.04.13-ны 65,<br>➢ 2 дугаар улирлын биелэлтийг 2020.06.23-ны 120,<br>➢ 3 дугаар улирлын биелэлтийг 2020.09.25-ны 175,<br>➢ 4 дүгээр улирлын биелэлтийг 2020.12.23-ны 244 дугаартай албан бичгээр Нийслэлийн Архивын газарт тус тус хүргүүлэн ажилласан. | | | | |
| 6 | 2 | 2020.05.27<br>№189<br>Тогтоолд өөрчлөлт оруулах тухай<br><br>"Түүхий нүүрс хэрэглэхийг хориглох тухай" Засгийн газрын 2018 оны 2 дугаар сарын 28-ны өдрийн 62 дугаар тогтоолын 2 дахь заалтыг хүчингүй болсонд тооцсугай.<br>2. Улаанбаатар хотын Баянзүрх дүүргийн 20, Сонгинохайрхан дүүргийн 21, Хан-Уул дүүргийн 12, 13, 14 дүгээр хороодын нутаг дэвсгэр энэ тогтоолын 1 дүгээр зүйлд хамаарахгүй байхаар тогтоосугай.<br>1. Улаанбаатар хотын Баянгол, Баянзүрх, Сонгинохайрхан, Сүхбаатар, | ➢ НОК-ын 2020 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн 13 дугаар /өргөтгөсөн/ хурлын тэмдэглэлийн 7.2 дахь заалтын дагуу ЗГ-ын 2018 оны 62, 2020 оны 189 дүгээр тогтоолыг албан хаагчдад танилцуулан мэдээлэл хүргэсэн.<br>➢ 2020 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн НУАШЗ-өөс өгсөн үүрэг даалгаврын 3 дахь заалтын дагуу сайжруулсан шахмал түлшийг хэрэглэх заавар, зөвлөгөө, сэрэмжлүүлгийг байгууллагын цахим хуудсаар дамжуулан иргэд олон нийтэд хүргэсэн. | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | Хан-Уул, Чингэлтэй дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэх тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжээс бусад иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудыг 2019 оны 5 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн түүхий нүүрс хэрэглэхийг хориглосугай. | | | | | |
| 7 | 2 | 2020.11.11<br>№178<br>Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай<br><br>Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацаанд Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10.3, 10.4-т заасан арга хэмжээг хэрэгжүүлж ажиллахыг гамшгаас хамгаалах алба, аймаг, нийслэлийн Засаг дарга, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээдийн удирдлагад, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10.9-д заасан шаардлагад нийцүүлэн холбогдох удирдамжийг баталж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Шадар сайд, Улсын онцгой комиссын дарга Я.Содбаатарт үүрэг болгосугай. | ➢ Байгууллагын гамшгаас хамгаалах төлөвлөгөөг 2020.10.15-ны өдөр шинэчлэн батлуулсан.<br>➢ Гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэгт зориулан байгууллагаас хувцас хэрэглэлээр хангаж, 2020 оны 10 дугаар сарын 21,23,27-ны өдөр урьдчилсан сэргийлэх үзлэгт штабын бүрэлдэхүүн хамрагдсан.<br>➢ 10 дугаар сарын 29-ний өдөр Багануур дүүргийн гамшгаас хамгаалах бэлэн байдлын нэгдсэн үзлэгт 65 байгууллагууд Нацагдоржийн талбай дээр цугларан ёслолын жагсаал хийж, үүргэвчний бүрэн байдлыг шалгуулсан ба Багануур үйлдвэрлэл, технологийн парк ОНӨТҮГ-ын штабын бүрэлдэхүүн амжилттай оролцсон.<br>➢ Цар тахалтай холбоотой ЗГ-ын тогтоолын хэрэгжилтийг хангаж, ажилчдыг гэрээсээ ажиллах нөхцөлийг бүрдүүлэн хамт олны 2 удаагийн цахим хурлыг зохион байгуулсан.<br>➢ Мөн Нийслэлийн удирдах ажилтны шуурхай цахим зөвлөгөөнд газрын дарга оролцсон.<br>➢ Ажилтнууд гэрээсээ ажиллахад ямар нэгэн хүндрэл бэрхшээл гараагүй.<br>➢ Цалин хөлс хугацаандаа олгогдсон.<br>➢ ЗГ-ын 2020 оны 178 дугаар тогтоолын хүрээнд гарсан НЗД-ын А/1241,1242 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангаж дараах ажлуудыг зохион байгуулан ажилласан. Үүнд:<br>• НЗД-ын А/1241 дүгээр захирамжийн хүрээнд | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | ✓ Албан хаагчдын амны хаалтын хэрэглээг хэвшүүлэн, ажилчдыг Паркийн нэгж болох Монхимо ХХК-ийн бүтээгдэхүүн /санитол/ гар халдваргүйжүүлэх бодисоор хангасан.<br>✓ Маскгүй иргэнд үйлчлэхгүй байх шаардлагыг тавьж байгаа ба "Масктай үйлчлүүлнэ үү" уриалгыг хаалганы гадна байршуулан мөрдөж ажиллаж байна.<br>✓ Захирамжийн дагуу 12 хүртэлх насны хүүхэдтэй албан хаагчдыг гэрээр ажиллуулах тухай Газрын даргын 2020 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн А/32 дугаар тушаалыг гарган хэрэгжилтийг ханган ажиллаж байна<br>• НЗД-ын А/1242 дугаар захирамжийн хүрээнд<br>✓ Манай байгууллагад ажлын байр Түрээслүүлэгч "Мэдээлэл холбоо сүлжээ" ТӨХХК нь халдвар хамгааллын дэглэмийг чанд сахин ажлын байранд халдваргүйжүүлэлтийг мэргэжлийн байгууллагаар хийлгэсэн.<br>✓ Газрын даргын 11 дүгээр сарын 12-ны өдрийн А/33 дугаар тушаалаар ажилтан албан хаагчдын 70%-г "Бүх нийтийн бэлэн байдлын зэрэг"-т шилжүүлсэн хугацаанд гэрээсээ ажиллах нөхцөлөөр хангасан.<br>✓ БҮТП ОНӨТҮГ-ын даргын А/33 тушаалаар: "Мэдээлэл холбоо сүлжээ" ТӨХХК-ийн төв хаалгаар хязгаарлалт тогтоосон хугацаанд ажиллах 5 ажилтан нэвтрэхдээ амны хаалт бээлий зүүн, гараа ариутгаж, биеийн халууныг үзүүлэн нэвтэрсэн.<br>✓ Зайлшгүй шаардлагатайгаас бусад тохиолдолд гэрээсээ гарахгүй байх уриалгыг бэлтгэж байгууллагын цахим хуудсанд байршуулан иргэд, олон нийтийг уриалсан.<br>✓ Мөн албан хаагчид өөрийн төрөл садан найз нөхөд, таньж мэдэх хүмүүстээ уриалсан.<br>✓ Корона вирусээс урьдчилан сэргийлэх зөвлөмж, мэдээлэл авах утас, цаг үеийн мэдээ | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | зэргийг байгууллагын цахим хуудсаар тогтмол хүргэж байна. | | | | |
| | | Хэсгийн дундаж | | 100% | 100% | | |
| | | Нийт дундаж | | 100% | | | |

ТАЙЛАН ХЯНАСАН:
БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК
ОНӨТҮГ-ЫН ДАРГА Ч.ЭЛБЭГСАЙХАН

ТАЙЛАН ГАРГАСАН:
ЗАХИРГААНЫ АЛБАНЫ АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Э.ЭНХЗАЯА

## “БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ ТЕХНОЛОГИЙН ПАРК” ОНӨТҮГ

## ХЭРЭГЖИЛТИЙН 2020 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ДҮНГИЙН ТОВЧОО

2020 оны 12 дугаар сарын 18 Багануур дүүрэг

| Хууль тогтоомж | | Нийт | МУ-ын хууль | УИХ-ын тогтоол | УИХ-ын байнгын хорооны тогтоол | Ерөнхийлөгчийн зарлиг | ҮАБЗ-ийн зөвлөмж, тэмдэглэл | Засгийн газрын тогтоол | Ерөнхий сайдын захирамж | Засгийн газрын хуралдааны тэмдэглэл | Засгийн газрын албан даалгавар | Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын | Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хурлын тэмдэглэл |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Хяналтад авсан нийт шийдвэрийн тоо | | 7 | | | | | | 7 | | | | | |
| Хяналтад авсан нийт зүйл заалтын тоо | | 13 | | | | | | 13 | | | | | |
| Бүрэн хэрэгжсэн | 100% | 13 | | | | | | | | | | | |
| Хэрэгжих шатанд | 70% | | | | | | | | | | | | |
| Хэрэгжилт хангалтгүй | 30% | | | | | | | | | | | | |
| Хэрэгжээгүй | 0% | | | | | | | | | | | | |
| Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй | | | | | | | | | | | | | |
| Биелэлтийн дундаж % | | 100 | | | | | | | | | | | |

ДҮГНЭСЭН:
БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК
ОНӨТҮГ-ЫН ДАРГА Ч.ЭЛБЭГСАЙХАН